



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/249

Мандалговь

Үзүүлэх сургууль зохион
явуулах тухай


Цэргийн албаны тухай хуулийн 33.10, Дайчилгааны тухай хуулийн 28.1.1, 31.2, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.1.3-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Говийн бүсийн аймаг, сумдын ЗДТГ-ын цэргийн бэлтгэл сургалт тус аймагт зохион явагдах болсон тул сургалтыг 2017 оны 08 дугаар сарын 02-05-ийг дуустал Бүрдийн уянга хүүхдийн зусланд зохион явуулсугай.

Хоёр. Орон нутагт дайчилгааны даалгаварыг биелүүлэх, орон нутгийн цэргийг зохион байгуулах үзүүлэх сургуульд Адаацаг сумын Батлан хамгаалах товчоо, дайчилгааны даалгавартай хүн, техникийг зарлан дуудаж дайчилгааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллуулахыг Адаацаг сумын Батлан хамгаалах товчооны дарга /Ж.Батхөлөг/-д үүрэг болгосугай.

Гурав. Цэргийн бэлтгэл сургалтанд сумдын ЗДТГ-ын дарга нарыг бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Дөрөв. Сургалтыг осол авааргүй, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж цэргийн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг цэргийн штабын дарга /хурандаа Б.Амаржаргал/-д хариуцуулсугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

0200710